



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/457

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтууд, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт драмын театр болон аймгийн Музей байгуулагдсаны түүхт 70 жилийн ойг тохиолдуулан байгууллагын түүхэн хөгжил дэвшил, ололт амжилт, алдар цуутнуудыг сурталчлан таниулах зорилго бүхий ном хэвлүүлэхэд тус бүрд 5 сая нийт 10 000 000 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Ном хэвлүүлэхэд шаардлагатай 10 000 000 төгрөг /арван сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.2 дахь Өв соёлын арга хэмжээний тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 27-ны өдрийн
А/457 дугаар захирамжийн хавсралт



**НОМ ХЭВЛҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛАХ
ХӨРӨНГИЙН ТООЦОО**

Д/д	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хөгжимт драмын театрын 70 жилийн ойн ном	250	20000	5000000
2	Музейн 70 жилийн ойн ном	250	20000	5000000
	Нийт			10000000

-oOo-